



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/312

Булган сум

Эрх шилжүүлэн гэрээ шууд
байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.4, 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны 108 дугаар тушаалаар батлагдсан “Зураг төслийн жишиг үнийн дүрэм” БД 81-16-20, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 2.8 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал эмнэлгийн шинэ лабораторийн барилгын зураг төсвийн аймгийн оролцооны 15,000,000 (арван таван сая) төгрөгөөр зураг төсөв боловсруулах гэрээ байгуулах эрхийг Мал эмнэлгийн газрын дарга (Г.Одсүрэн)-д олгосугай.

2. Зураг төсөл боловсруулах ажилд чанарын болон хугацааны хяналт тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Ү.Бямбасүрэн)-д даалгасугай.

3. Зураг төслийн ажлыг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний зардлын батлагдсан төсвөөс гэрээнд заагдсан үнийн дүнгээр санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Б.Ариунболд)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг даргын тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Гантулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ДҮРЭВ-ОЧИР

